



**ЗАВХАН АЙМГИЙН
ТОСОНЦЭНГЭЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2015 оны 10 сарын 12 одор

Дугаар 42

Шумуултай

**Г Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газар байгуулах тухай**


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "ж" дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, Төрийн бопон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.2.4, дахь заалтуудыг үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Шинэчлэлийн засгийн газрын "Сумын төвийн шинэчлэл" төслийн хүрээнд хийгдэж буй цэвэр усан хангамж , ариутгах татуурга , цэвэрлэх байгууламж , дулааны шугам сүлжээ , уурын зуухны өргөтгөлийн цогц ажил дуусч байгаа тул Тосонцэнгэл сумын төсвийн газруудыг чанар стандарт хангасан дулаанаар хангах, хэрэглэгчдийг унд, ахуйн стандартад тохирсон усаар тасралтгүй хангаж, экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирох усыг байгальд нийлүүлэх үүрэг бүхий нийтийн аж ахуй, ус сувгийн "Тосон Очирт хайрхан" нэртэй орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсугай.

Хоёр. Тосонцэнгэл сумын "Тосон Очирт хайрхан" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нийтийн аж ахуй, ус сувгийн газрын дүрмийг 1 дүгээр хавсралтаар, зохицуулах журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. "Тосон Очирт хайрхан" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд зохих хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид болон сумын Засаг дарга /Б.Төрмөнх/ нарт үүрэг болгосугай.

Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Лхагважав/-д даалгасугай.

ДАРГА  Л.БАТТУЛГА

D/2015/TOGTOOL

157 100